



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/177

Өмнөдэлгэр сум

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай**


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дүгээр зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.4, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 394 дугаар тогтоол “Төрийн өмчит компани байгуулах тухай”, 2023 оны 269 дугаар “Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албыг татан буулгах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын алба (6528627) татан буугдаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (6829147)-д газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурьдсанаар шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан байгууллагатай гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Ё.Мөнх-Өлзий/-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний А/217, 2021 оны 12 дугаар сарын 28-ний А/215 дугаар захирамжуудыг хүчингүй болсонд тооцсугай.



Р.ЭНХТӨР

сумын Засаг даргын 2026 оны
05 дүгээр сарын 29-ны өдрийн
А/177 дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлсэн болон шилжүүлэн авсан иргэний жагсаалт

Шилүүлэн авч буй АА-н нэгж, иргэний нэр	Регистрийн дугаар	Газрын хэмжээ /м2/	Хугацаа /жил/	Газрын байршил	Зориулалт	Нэгж талбарын дугаар	Шилжүүлсэн АА-н нэгж, иргэний нэр	Шилжүүлсэн үндэслэл
"Хөдөө аж ахуйн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани	6829147	10000	3	Бортын гол	Тэжээл бордооны агуулах	2314002998	Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын алба	Татан буугдсан
"Хөдөө аж ахуйн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани	6829147	11291	5	Шар тал	Үр тарианы усалгааны тариалан	2314004212	Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын алба	Татан буугдсан
Дүн		21291						